Scanned with CamScanner

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 27,828,283.2 мянган төгрөг болж, 5,545,861.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 7,088,202.6 мянган төгрөгийн дуусаагүй барилга, байгууламжийн өртөг нэмэгдсэн, 30,543.5 мянган төгрөгийн элэгдлээрээ өртгөө нөхсөн 25 нэр төрөл бүхий хөрөнгөнд үнийг шинэчлэл тогтоож 19,730.0 мянган төгрөгөөр орлогод авсан, 1,737,721.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос голлон шалтгаалжээ.
- Өр төлбөрийн дансны үлэгдэл 848,226.4 мянган төгрөг болж, 810,427.4 мянган төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбоотой 6,240.1 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж, 2025 оны 12 сарын байрны түрээсийн зардлын 5,615.8 мянган төгрөгийн, цахилгаан өргөтгөлийн барилга угсралтын ажлын барьцааны 823,386.8 мянган төгрөгийн өр төлбөрийг шинээр бүртгэсэнтэй холбоотой.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,517,651.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй холбоотой.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад 3,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг санхүүгийн программыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Тайлант онд нэмэгдсэн хасагдсан өөрчлөлт байхгүй.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,267,350.9 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн ирүүлсэн төсвийн төслийн саналыг 1,939,271.4 мянган төгрөгөөр бууруулж, 2,328,079.5 мянган төгрөгөөр баталжээ.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсантай холбогдуулан бараа, ажил, үйлчилгээний зардлыг 142,144.8 мянган төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 2,185,934.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 7,902,900.0 мянган төгрөгөөр баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал санхүүжилтэд 2,013,845.8 мянган төгрөг, хөрөнгийн санхүүжилтэд 7,902,895.8 мянган төгрөг, нийт 9,916,741.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн үйл ажиллагааны орлогоос 129,078.6 мянган төгрөгийг орлого бүрдүүлсэн.

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 6 арга хэмжээг санхүүжүүлэхэд урсгал зардалд 1,793,423.8 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 7,088,202.6 мянган төгрөгийг тус тус зарцуулж, оны эцэст урсгал санхүүжилтээс 349,500.6 мянган төгрөгийг, хөрөнгийн санхүүжилтээс 814,693.2 мянган төгрөг, нийт 1,164,193.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,881,626.4 мянган төгрөг буюу 88.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 333,816.5 мянган төгрөгөөр, харуул, хамгаалалтын зардлыг 561.4 мянган төгрөгөөр, байр ашиглалтын зардлыг 18,144.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийг 1,489.0 мянган төгрөгөөр, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлыг 38,500.0 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 814,697.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.



Scanned with CamScanner

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71201 | **Чөлөөт бүсийг хөгжүүлэх** | **10,088,834.7** | **8,881,626.4** | **1,207,208.3** | **88.0** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,983,059.3 | 1,649,242.8 | 333,816.5 | **83.2** |
| 80219 | Харуул, хамгаалалтын зардал | 10,550.4 | 9,989.3 | 561.1 | **94.7** |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 50,060.0 | 31,915.7 | 18,144.3 | **63.8** |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 103,765.0 | 102,276.0 | 1,489.0 | **98.6** |
| 81569 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 38,500.0 | - | 38,500.0 | **0.0** |
| 80918 | Бусад | 7,902,900.0 | 7,088,202.6 | 814,697.4 | **89.7** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл"-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн алба нь 2024 оны А/13 дугаар тушаалаар бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн орон тоог 50 байхаар баталжээ. Төсвийн тухай хуульд 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 155 дугаар тушаалаар 42 орон тоотой байхаар батлаж, гүйцэтгэлээр 42 хүний орон тоогоор ажилласан байна. Тайлант онд цалингийн зардалд нийт 1,557,552.3 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 1,314,211.3 мянган төгрөгийг олгож, батлагдсан төсвийг 243,341.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулжээ.
2. Байгууллагын дотоод журмын 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу Захирагчийн 2023 оны 05 дугаар сарын 16 ний өдрийн А/15 дугаар тушаалаар нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийг 30.0-80.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 1.0 мянган төгрөгөөр тооцож олгохоор баталсан байна. Тайлант онд хоол, унааны хөнгөлөлтийн зардалд 185,973.5 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 233,951.1 мянган төгрөгийг олгож, батлагдсан төсвийг 47,977.6 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна. Энэ нь төсвийн төслийг тооцоо судалгаанд үндэслэлгүй боловсруулсантай холбоотой байна.
3. Гадаад албан томилолт болон хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал гараагүй.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Байгууллага нь тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар 4,680.0 мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр зарцуулалт хийгдээгүй, үлдэгдэл 4,680.0 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01

Scanned with CamScanner

**3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант хугацаанд бараа материал ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний талаар санал оруулсан боловч дэмжигдээгүй худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй.

Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн 110/35/6кв-ын 2*25 МВА чадалтай Сүхбаатар дэд станцын өргөтгөл ажлыг "Улаанбаатар электромонтаж" ХХК тайлант хугацаанд 7,902,900.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг зарцуулан нийт 11,108,216.9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий өртгөөр хийж гүйцэтгэн 2025 оны 12 дугаар сарын 23-нд Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлт гарч хүлээн авсан байна.



Scanned with CamScanner

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Ирмүүн хантайшир аудит" ХХК-ийн ахлах аудитор Б.Норхлоо, аудиторын туслах Д.Отгонсэнгээ нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг Г.Сэр-Од, захирал Д.Бямбацэрэн, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер А.Цогбаяр газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн алба нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн зардлын дүн 2,526,859.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25,268.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага улсын төсвийн хөрөнгөөр олон нийтийг хамарсан шинэ жил аялал зугаалга зэрэг үйл ажиллагаа зохион байгуулахгүй, бичгийн цаас, хор зэрэг бичиг хэргийн зардлыг бууруулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзэхэд хуулийн дагуу мэдээллүүдийг бүрэн байршуулсан байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ



Scanned with CamScanner

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Алтанбулаг чөлөөт бүсийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулан завсрын аудит гүйцэтгэж, мөнгөн хөрөнгө, авлага бараа материалын дансанд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар илэрсэн 26,540.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгч, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин нягталж дүнг аудитын тайланд тусгасан.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар нийт 525,630.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 515,878.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 9,751.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлснээс 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 албан шаардлагын бүрэн хэрэгжүүлээгүй байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилт дунджаар 75.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Д/д | Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| 2 | Албан шаардлага | 3 | 515,878.7 | 2 | 515,878.7 | 66.6 |
| 3 | Зөвлөмж | 1 | 9,751.7 | 1 | 9,751.7 | 100.0 |
| | **Нийт дүн** | **4** | **525,630.4** | **3** | **525,630.4** | **75.0** |

Өмнөх аудитаар өгсөн үндсэн хөрөнгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 553 ширхэг 1,432,323.0 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа, дансны үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитаар илэрсэн дараах асуудлуудад дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын хавсралтад заасан санхүүгийн тайлангийн маягтыг тодорхой болгож сайжруулах талаар эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;
2. Тайлант хугацаанд барьж дууссан улсын комисс хүлээн авсан 11,108,216.9 мянган төгрөгийг цахилгаан хангамжийн өргөтгөлийн барилга, байгууламжийг Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын шийдвэр гаргуулж, данс бүртгэлд тусгасан эсэх;



Scanned with CamScanner

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлангийн алдаатай холбоотой залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 2,748,870.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2,503.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн 1 акт тогтоож, 2,706,258.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 40,108.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн 2,748,870.9 мянган төгрөгийн алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,723,602.3 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй 1 ажилтанд 2,503.5 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон.

Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Ээлжийн амралтын болон ажилласан хоногийн цалинг давхардуулан олгосныг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

### 5.2.1 Албан шаардлага

Тайлант онд "Бэх очир чөлөө бүс" ХХК-тай холбоотой 3,000.0 мянган төгрөг, "Наран энержи трейд чөлөөт бүс" ХХК-аас авах 1,500.0 мянган төгрөг, "Алтан үрэл ингэт трейд чөлөөт бүс" ХХК-тай холбоотой 1,885.7 мянган төгрөг, "Үржих тариан түрүү чөлөөт бүс" ХХК-иас авах 1,200.0 мянган төгрөг, нийт 7,585.7 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Байгууллага хоорондын тооцоогоор үүссэн авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2.2 Албан шаардлага

Төсвийн санхүүжилтээр 60,881.0 мянган төгрөгийн барилгын засвар үйлчилгээг батлагдсан зураг төсөвгүй, сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй нийт 4 аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн.

Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно".Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Scanned with CamScanner

тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан зураг төсөлгүй, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулалгүй засварын ажил гүйцэтгүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

**5.2.3 Албан шаардлага**

Өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авсан бүрэн хэрэгжээгүй, эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээр өртгөө нөхөн үлдэгдэлгүй болсон, ашиглалтгүй нийт 2,637,791.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд: Ерөнхий төлөвлөгөө, инженер геологийн судалгаа, геодизийн хэмжилтийн ажлын зураг зэрэг 255,275.0 мянган төгрөгийн баримт бичиг, 421,394.2 мянган төгрөгийн цаашид ашиглах боломжгүй хашаа шороон зам, 2011 онд орлогод авсан 1,799,699.7 мянган төгрөгийн огт ашиглаагүй усны шугам хоолой, 161,422.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.4-д нягтлан бодох бүртгэл хөтлөгч нь хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2/ "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төрийн өмчийн хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн ашиглалт үнэ цэнийг нэмэгдүүлэн, үнэ шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй, өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

**5.3.1 Зөвлөмж**

Цаашид анхаарах зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*1.Илрүүлэлт:* Ажилчдад нийт 36,087.8 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл цалинг ажилчдын ажлын үр дүнг үнэлсэн боловч үнэлгээ, үр дүнтэй уялдуулаагүй хавтгайруулан олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтнуудад ажлын үр дүн, үнэлгээтэй уялдуулан үр чадварын нэмэгдлийг олгож, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах.



Scanned with CamScanner

*2 Илрүүлэлт:* Санхүүжилтийн эх үүсвэрийн дутагдалтай холбоотой байрны түрээсийн 12 сарын зардлын 4,012.1 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй гарсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-дэд "хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагаатай холбоотой үүссэн өр төлбөрийг бүрэн барагдуулж, цаашид өр төлбөр үүсгэхгүй, төсвийг зохистой удирдаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ ХЭРЭГЛЭЭНД

Scanned with CamScanner

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй ээлжийн амралтын цалинг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон. | 1 | 2,503.5 | 1 | 2,503.5 | | | | | | | | | |
| 2 | Төсвийн нэмэлт санхүүжилтээр барилгын засвар үйлчилгээг батлагдсан зураг төсөвгүй, сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй нийт 4 аж ахуй нэгжтэй шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн | 1 | 60,881.0 | | | 1 | 60,881.0 | | | | | | | |
| 3 | Байгууллага нь харилцагч байгууллагуудаас авах хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй. | 1 | 7,585.7 | | | 1 | 7,585.7 | | | | | | | |
| 4 | Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгүүдэд үнэ шинэчлэлийн арга хэмжээг аваагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлээгүй | 1 | 2,637,791.8 | | | 1 | 2,637,791.8 | | | | | | | |
| 5 | Санхүүжилтийн эх үүсвэрийн дутагдалтай холбоотой байрны түрээсийн зардалтай холбоотой өр төлбөр үүсгэнэ. | 1 | 4,021.1 | | | | | 1 | 4,021.1 | | | | | |
| 6 | Ажилтнуудад ур чадварын нэмэгдэл цалинг хийсэн ажлын үр дүн, үнэлгээ уялдуулаагүй, хавтгайруулан олгосон. | 1 | 36,087.8 | | | | | 1 | 36,087.8 | | | | | |
| | Дүн | 6 | 2,748,870.9 | 1 | 2,503.5 | 3 | 2,706,258.5 | 2 | 40,108.9 | - | - | - | - | - |



Scanned with CamScanner

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр | Дугаар 116/А0150169 | Улаанбаатар хот

САГ-2026/6/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 1 ажилтанд 2,503,486.00 (хоёр сая таван зуун гурван мянга дөрвөн зуун наян зургаан) төгрөгийн ээлжийн амралтын цалинг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн алба нь ажилтанд үндсэн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулж олгосон нийт 2,503,486.00 (хоёр сая таван зуун гурван мянга дөрвөн зуун наян зургаан төгрөг) төгрөгийг буруутай албан тушаалтан Хүний нөөцийн хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Отгонцэцэг, тооцооны нягтлан бодогч Ө.Содов нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сангийн Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн албаны захирагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Азжаргал/, Бүртгэл санхүүгийн хэлтсийн дарга /Б.Зоригоо/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — А.ЦОГБАЯР

"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Д.БЯМБАЦЭРЭН

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264130*

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ 1526300076

Scanned with CamScanner

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр      Дугаар 539/А0150169      Улаанбаатар хот

САГ-2026/6/НА-СТА-ТШ3

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн нэмэлт санхүүжилтээр 60,891,000.00 (жаран сая найман зуун ерэн нэгэн мянган) төгрөгийн барилгын засвар үйлчилгээг батлагдсан зураг төсөвгүй, сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж нийт 4 аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлэн урсгал зардал бүртгэсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй", 4.2.1.8-т "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан зураг төсөвгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулалгүй засварын ажил гүйцэтгүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт[1] ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны захирагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Азжаргал/, бүртгэл санхүүгийн хэлтсийн дарга /Б.Зоригоо/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.БЯМБАЦЭРЭН

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0225 SAG-3\ Docx

Scanned with CamScanner

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 540/А0150169 Улаанбаатар хот
САГ-2026/6/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авсан ч бүрэн хэрэгжээгүй, эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхөж үлдэгдэлгүй болсон нийт 2,637,791,834.00 (хоёр тэрбум зургаан зуун гучин долоон сая долоон зуун ерөн нэгэн мянга найман зуун гучин дөрвөн) төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд: Ерөнхий төлөвлөгөө, инженер геологийн судалгаа, геодизийн хэмжилтийн ажлын зураг зэрэг 255,275,000.00 (хоёр зуун тавин таван сая хоёр зуун далан таван мянган) төгрөгийн баримт бичиг, 421,394,200.00 (дөрвөн зуун хорин нэгэн сая гурван зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун) төгрөгийн цаашид ашиглах боломжгүй хашаа шороон зам, 2011 онд орлогод авсан 1,799,699,743.00 (нэг тэрбум долоон зуун ерэн есөн сая зургаан зуун ерөн есөн мянга долоон зуун дөчин гурван) төгрөгийн огт ашиглаагүй усны шугам хоолой, 161,422,891.00 төгрөгийн тавилга эд хогшил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа,түүнийг

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр. Утас 51-264230*

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн ашиглалт үнэ цэнийг нэмэгдүүлэн, үнэ шинэчлэн тогтоох арга хэмжээг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны захирагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Азжаргал/, бүртгэл санхүүгийн хэлтсийн дарга /Б.Зоригоо/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | А.ЦОГБАЯР |
| "ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Д.БЯМБАЦЭРЭН |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр. Утас 51-264230*



Scanned with CamScanner

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр  Дугаар 541/А0150169  Улаанбаатар хот

САГ -2026/6/НА -СТА -ПШ3

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд "Бэх очир чөлөөт бүс" ХХК-тай холбоотой 3,000,000.00 (гурван сая) төгрөг, "Наран энержи трейд чөлөөт бүс" ХХК-наас авах 1,500,000.00 (нэг сая таван зуун мянган) төгрөг, "Алтан үрэл ингэт трейд чөлөөт бүс" ХХК-тай холбоотой 1,885,700.00 (нэг сая найман зуун наян таван мянга долоон зуун) төгрөг, "Үржих тариан түрүү чөлөөт бүс" ХХК-иас авах 1,200,000.00 (нэг сая хоёр зуун мянган) төгрөг, нийт 7,585,700.00 (долоон сая таван зуун наян таван мянга долоон зуун) төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээг аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д " эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй",4.2.1.10-т" аудитаар илэрсэн алдаа, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллага хоорондын тооцоогоор үүссэн авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны захирагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Азжаргал/, бүртгэл санхүүгийн хэлтсийн дарга /Б.Зоригоо/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.БЯМБАЦЭРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Scanned with CamScanner